



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 417

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 1,632,500,000.00 (нэг тэрбум зургаан зуун гучин хоёр сая таван зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 544,166,667.36 (таван зуун дөчин дөрвөн сая нэг зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран долоон төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны дарга Г.Мөнхбаяр, Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбаяр, Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга П.Гомбодорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ
132001984
20-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 09 дугаар сарын 13-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

АЙМАГ ДУНДЫН ОТРЫН БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨНД БҮРТГЭЛТЭЙ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг
Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт								
1	Трактор /50-77УР улсын дугаартай/	2021.12.31	ш	1	78,000,000	78,000,000.00	25,999,999.92	52,000,000.08
2	Хүнд диск	2021.12.31	ш	1	20,000,000	20,000,000.00	6,666,666.72	13,333,333.28
3	Үрлүүр	2021.12.31	ш	1	16,500,000	16,500,000.00	5,500,000.08	10,999,999.92
	Дүн			3		114,500,000.00	38,166,666.72	76,333,333.28
Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт								
1	Трактор /50-52УР, 50-73УР, 50-78 УР, 50-79 УР, 50-81УР, 50-82УР, 50-83УР, 50-85УР, 50-86УР, 50- 87УР, 50-88УР, 89-02УР улсын дугаартай/	2021.12.31	ш	12	78,000,000	936,000,000.00	311,999,999.04	624,000,000.96
2	Хүнд диск	2021.12.31	ш	12	20,000,000	240,000,000.00	80,000,000.64	159,999,999.36
3	Үрлүүр	2021.12.31	ш	12	16,500,000	198,000,000.00	66,000,000.96	131,999,999.04
4	Циргүүлийн жатка	2021.12.31	ш	1	32,500,000	32,500,000.00	10,833,333.36	21,666,666.64
5	Хаман боогч /дөрвөлжин/	2021.12.31	ш	1	32,500,000	32,500,000.00	10,833,333.36	21,666,666.64
6	Өвс хуйлан боогч	2021.12.31	ш	1	55,500,000	55,500,000.00	18,499,999.92	37,000,000.08
7	Хальс ороогч	2021.12.31	ш	1	23,500,000	23,500,000.00	7,833,333.36	15,666,666.64
	Дүн			40		1,518,000,000.00	506,000,000.64	1,011,999,999.36
						1,632,500,000.00	544,166,667.36	1,088,333,332.64
	НИЙТ ДҮН			43		(Нэг тэрбум зургаан зуун гучин хоёр сая таван зуун мянга)	(Таван зуун дөчин дөрвөн сая нэг зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран долоон төгрөг гучин зургаан мөнгө)	(Нэг тэрбум наян найман сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин хоёр төгрөг жаран дөрвөн мөнгө)